



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/116

Шивээговь сум

Хяналт шалгалтын ажил зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрөөс баримталж байгаа хүнсний эрүүл ахуйн чиглэлээр сумын хэмжээнд хяналт шалгалтын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Гантуяа  
(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Л.Чанцалмаа  
(1-р Багийн Засаг дарга)  
Б.Алтансүх  
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)  
Г.Зулхүү  
(Цагдаагийн дэд ахлагч)

Нарийн бичгийн дарга: Д.Амартүвшин  
(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Хяналт шалгалтын ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.


4.Ажлыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг дүгнэн зохих арга хэмжээг авч ажиллан тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны  
09 сарын 03 өдрийн  
А/116 дугаар захирамжийн хавсралт



Хяналт шалгалтын ажил зохион байгуулах ажлын удирдамж

#### Нэг. Зорилго

Сумын хүнсний худалдаа, Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж албан байгууллагад хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч ажиллахад оршино.

#### Хоёр. Хугацаа

Хяналт шалгалтын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэх.

#### Гурав. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Хяналт шалгалтаар илэрсэн аж ахуй нэгж, албан байгууллага, хувиараа бизнэс эрхлэгчдийн хүнсний бүтээгдэхүүний зөрчлийг холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

#### Дөрөв. Зохион байгуулагдах ажил

- Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах
- Хүнсний аюулгүй байдлыг хангаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг хураах, устгах арга хэмжээ авч ажиллах
- Хүнсний худалдаа эрхлэгчдийн худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг хянаж шалгах
- Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, албан байгууллагын үйлчилгээний заал, танхим, гал тогооны ариун цэвэрт шалгалт хийх
- Бүтээгдэхүүний хадгалалт, агуулахын шаардлага хангасан байдалд хяналт шалгалт хийх
- Хүнсний худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлтэй холбоотой баримт бичгийн бүрдлийг шалгах